

**БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ СУМЫН НУТАГТ  
ОРШИХ ЗАХЦАГ УУЛ, ХУДАГ БАЙШИНТ ТӨМРИЙН  
ХҮДРИЙН ОРДЫГ АШИГЛАХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Аж ахуйн нэгжийн нэр: “Фокус метал майнинг” ХХК

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-021702, MV-015152, MV-012263

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 5567319

Улаанбаатар хот

2022 он

ГАРЧИГ

- ОРШИЛ .....
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....
  2. 2022 ОНЫ АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ
  3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....
  4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....
  5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....
  6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....
  7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....
  8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....
  9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....
  10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....
  11. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА       ЗОХИОН       БАЙГУУЛАЛТЫН       ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....
  12. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....

ДҮГНЭЛТ

ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД

## ОРШИЛ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний эрх бүхий “Евро Азиа Эко” ХХК-аар Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Захцаг уул, Худаг байшинт төмрийн хүдрийн ордыг ашиглах төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийж гүйцэтгүүлсэн ба мэргэжил арга зүйн зөвлөгөө авсны үндсэн дээр 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлыг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, “Усны тухай” хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар баталсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны шинжээчийн гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлт, нарийвчилсан үнэлгээ зэргийг үндэс болгов.

Төслийн гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тодорхойлох, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх, олборлолтыг зохистой ашиглах талаар зөвлөмж боловсруулах, уул уурхайн олборлолт хийх явцад мөрдөж ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулах зэрэг нь зайлшгүй шаардлагатай юм.

## **НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:**

**1.1 Төслийн нэр:** Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Захцаг уул, Худаг байшинт төмрийн хүдрийн ордыг ашиглах төсөл.

### **1.2 Төслийн зорилго:**

Төсөл хэрэгжүүлэгч “Фокус метал майнинг” ХХК нь нөөц нь тогтоогдож батлагдсан MV-012263, MV-015152, MV-021702 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Худаг байшинт, Худаг байшинт-1 төмрийн хүдрийн ордуудыг Монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр уурхайлалтын үйл ажиллагаа явуулж улмаар Монгол Улс, тухайн орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг бүрэн хийж орон нутагт хүлээлгэн өгөх зэрэгт энэхүү төслийн зорилго оршино.

### **1.3 Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгж:**

Төсөл хэрэгжүүлэгч компани нь 2008 онд “Монгол Металл Майнинг” ХХК нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд 2009 оноос Захцаг уул нэртэй газар орших 30.93 га талбай бүхий MV-015152 ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатайгаар эзэмшиж, АМГТХЭГ-ын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2008.07.17-ны 1082 тоот шийдвэрээр MV-012263 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл/анх 2006.11.30-нд Мон Лаа ХХК-д олгогдсон/-ийг “Эс Жи Групп” ХХК-иас “Монгол Металл Майнинг” ХХК-д шилжүүлэн авсан байна.

“Монгол Металл Майнинг” ХХК нь 2012 онд хамтарсан хөрөнгө оруулалттай компани болсон бөгөөд 2012.03.20-ны өдөр компанийн хууль ёсны нэрээ өөрчилж, “Фокус метал Майнинг” ХХК нэртэй болж улмаар тухайн орд газарт гадаад хөрөнгө оруулалтыг татан оруулсан байна.

Мөн тухайн ондоо Мон Лаа ХХК-д 2006 оны 12-р сарын 15-ны өдөр 12141Х тоот 3139 га Захцаг уул талбайд хууль заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал хайхыг зөвшөөрч 9011002117 тоот гэрчилгээг олгосон бөгөөд энэхүү тусгай зөвшөөрлийг 9019064099 тоот улсын бүртгэлийн дугаартай “Фокусметал Майнинг” ХХК-д 2012.05.16-ны өдөр шилжүүлэн авсан байна.

Тус компани нь 2012 оноос Худаг байшинтын орд газрыг ашиглах төсөлдөө гадаад хөрөнгө оруулалтыг татаж, БНХАУ-ын хөрөнгө оруулалт бүхий компани болж, улмаар төслийн талбайд баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлж, 2014 онд


баяжуулах үйлдвэрийн 1-р шугамыг ашиглалтад оруулсан бөгөөд 2014 оноос дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ ханшийн уналтаас үүдэн үйл ажиллагаа явуулахгүй өнөөдрийг хүртэл зогсоосон байдалтай байна.

**1.4 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:**

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Зайсангийн тойруу 27-1, Зайсан цэнтр, 605 Утас: 77036868

**1.5 Төслийн байршил, хэрэгжих орчны тойм зураг:**

“Захцаг уул, Худаг байшинт” төмрийн хүдрийн ордууд нь Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших бөгөөд нийт 977.12 га талбайг хамарна. Тус орд нь Улаанбаатар хотоос 250 км, Заамарын алтны уулын үйлдвэрлэлийн газраас 12 км, төмөр замын Орхон туул зөрлөгөөс 90 км, Эрдэнэт хотоос 80 км зайд байрлана.



Зураг 1. Төслийн талбайн байршил, талбайн хил

Хүснэгт 1. Төслийн талбайн солбилцол

№	Уртгаг	Өргөрөг	Талбай, га
MV-012263			
1	104° 15'50.94"	48° 18' 26.81"	79.52
2	104° 15'50.94"	48° 18' 51.82"	
3	104° 15' 0.94"	48° 18' 51.82"	
4	104° 15' 0.94"	48° 18' 26.81"	
MV-015152			
1	104° 15' 0.94"	48° 18' 16.81"	30.92
2	104° 15' 0.94"	48° 18' 34.82"	
3	104° 14' 33.94"	48° 18' 34.82"	
4	104° 14' 33.94"	48° 18' 16.81"	
MV-021702			
1	104° 14' 33.94"	48° 18' 34.82"	866.68
2	104° 15' 0.94"	48° 18' 34.82"	
3	104° 15' 0.94"	48° 19' 30.84"	
4	104° 14'23.23"	48° 19' 30.84"	
5	104° 14'23.23"	48° 19' 14.74"	
6	104° 14' 2.24"	48° 19' 14.74"	
7	104° 14' 2.24"	48° 18' 58.84"	
8	104° 13'33.13"	48° 18' 58.84"	
9	104° 13'33.13"	48° 18' 36.84"	
10	104° 13'12.15"	48° 18' 36.84"	
11	104° 13'12.15"	48° 18' 4.45"	
12	104° 13'56.02"	48° 18' 4.45"	
13	104° 13'56.02"	48° 17' 57.38"	
14	104° 13'41.89"	48° 17' 57.38"	
15	104° 13'41.89"	48° 17' 49.03"	
16	104° 13'28.29"	48° 17' 49.03"	
17	104° 13'28.29"	48° 17' 24.83"	
18	104° 13'47.24"	48° 17' 24.83"	
19	104° 13'47.24"	48° 17' 14.77"	
20	104° 13'17.9"	48° 17' 14.77"	
21	104° 13'17.69"	48° 16' 29.06"	
22	104° 14' 9.8"	48° 16' 29.06"	
23	104° 14' 9.8"	48° 16' 55.1"	
24	104° 14' 39.1"	48° 16' 55.1"	
25	104° 14' 39.1"	48° 17' 12.07"	
26	104° 15' 0.93"	48° 17' 12.07"	
27	104° 15' 0.94"	48° 18' 16.81"	
28	104° 14'33.94"	48° 17' 16.81"	

### 1.6. Төсөл хэрэгжих хугацаа

Худаг байшинт, Захцаг Уул нэртэй төмрийн хүдрийн орд газруудад 2008-2014 оны хооронд ил уурхайн аргаар ашиглалт, олборлолтын ажил явуулж өнөөдрийн байдлаар 628.23 мян. тн хүдэр олборлосон бөгөөд 6.558.4 мян.тн хүдэр үлдээд байна.

Уурхайн олборлолтын үйл ажиллагааг 2022 оны 2-р сарын 01-ээс эхлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд олборлолтыг 7 жилийн хугацаанд хийнэ гэж тооцоолов. Ашиглалтын эхний жилд уурхай байгууламжийн ажил, нээлтийн хөрс хуулалтын ажил хийгдэх бөгөөд ил уурхайгаас 1,541.4 мян.м3 хөрс хуулж, 355.1 мян.тн төмрийн хүдэр олборлоно.

### 1.7. Төслийн талбайн хүдрийн нөөц

Балансын нөөцөд хоосон ба сул эрдэсэжсэн хэсгүүдийг, хэрэв захын агуулгыг бууруулахгүй бол оруулж болохыг зөвшөөрсөн бөгөөд Худаг байшинт уулын төмрийн хүдрийн ордын хайгуулын ажлыг хүдрийн биетийг гадаргуугаас нь суваг малтаж сорьцлолт хийж гүн рүү нь өрмийн цооноогоор тодорхой тороор өрөмдөн судалж сорьцлон нөөц бодолтыг АМГТХЭГ-ын 1998 оны 27-р тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын нөөц баялгийн ангиллын түр журам”-ын дагуу тооцоолсон байдаг.

Нөөцийн тооцоог геологийн зүсэлтийн аргаар хийж, уг тооцоог геологийн блокийн аргаар давхар нягтлан хүдрийн нөөцийг гадаргуугаас дунджаар 100 ба 200 м гүн дэх огтлолуудын хэвтээ түвшинд бодитой /В/ ба боломжтой /С/ зэрэглэлээр тооцоолсон.

Ордын хэмжээнд нөөцийн зэрэглэлээрээ бодитой /В/ нөөцийн зэрэглэлийн 11 блок, боломжтой нөөцийн (С) зэрэглэлийн 15 блок тус тус ялгаж нөөцийн тооцоо хийгдсэн байна.

Бодитой нөөц /В/ нь 4373653.89 тн, боломжтой /С/ нөөц нь 2813047.25 тн буюу (В+С) зэргээр нийт 7186700.63 сая тн нөөцийг 2008 оны 04-р сарын 22-ны өдөр ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн.

#### Хүснэгт 2.

#### Худаг байшинтын төмрийн хүдрийн ордын геологийн нөөц

Хэсэгшили йн дугаар нөөцийн зэрэглэл	Огтлол ын дундаж талбай, м <sup>2</sup>	Огтлол хооронд ын зай, м	Хүдри йн эзлэхү үн жин, тн/м <sup>3</sup>	Хүдрийн нөөц		Хэсэгшили йн дундаж агуулга, %		Нөөцийн зэрэглэл
				м <sup>3</sup>	тн	Fe	S	
1-С-1	96	20	4.05	1920	7776	45.5	0.04	С
2-С-1	1848.4	80	4.05	147872	598882	45.9	0.03	
3-В-1	3953.9	100	4.05	395390	1601330	45.7	0.04	В
4-В-1	3105.7	100	4.05	310570	1257809	45.6	0.03	
5-В-1	2938.4	100	4.05	293840	1190052	45.9	0.03	
6-В-1	2349.1	100	4.05	234910	951386	46.3	0.04	
7-В-1	708.5	100	4.05	70850	286943	47.0	0.04	

<b>8-С-1</b>	385.4	90	4.05	34686	140478	44.2	0.04	С
<b>9-С-1</b>	79.5	20	4.05	1590	6440	41.6	0.04	
<b>Нийт нөөц</b>				<b>17111119.2</b>	<b>7186700.63</b>	<b>44.2</b>	<b>0.04</b>	<b>В+С</b>

### 1.8. Ил уурхай

Уурхайн бүх үе шатуудын хооронд тэлэлт хийх хамгийн бага ажлын талбайн өргөн нь 30 м багагүй байна. Гэвч зарим тохиолдолд хязгаарлагдмал орон зай бүхий нөхцөлд 20 м хүртэл багасаж болох юм. Уурхайн хүрээнд өртөх нөөцийн хэмжээг хамгийн их байлгах нөхцөлийг хангах үүднээс эцсийн уурхайн ёроол дахь траншейн замын өргөн нь хөдөлгөөний хоёр зурвастай буюу 15 м өргөнтэй (берм болон ус урсгах сувгийг багтаасан), 10% налуутай буюу 60 градус байна.


#### 1.8.1. Уурхайн ашиглалтад өртсөн байдал

Худаг байшинтын төмрийн хүдрийн MV-012263, MV-015152 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн ордын нөөцийг анх 2008 оны 05-р сарын 13-ны өдрийн №208 тоот тушаалаар бодитой (В) зэргээр 4,373.65 мян.тн, боломжтой (С) зэргээр 2,813.05 мян.тн хүдрийн нөөц батлуулсан. Худаг байшинтын уурхай нь 2008-2014 оны хооронд ил уурхайд олборлолтын ажил явуулсан бөгөөд өнөөдрийн байдлаар 628.23 мян.тн хүдэр олборлоод байна. Ил уурхайн жил бүр ашигласан нөөцийн хэмжээг АМГТГ-ын 2008-2020 оны хоорондох металл ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөний тайланг үндэслэн гаргасан бөгөөд олборлосон нөөцийн хэмжээг дараах хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт 3. Олборлосон нөөц /жил бүрээр/

Он	Олборлосон хүдрийн нөөц, мян.тн		Нийт, мян.тн
	В зэргээр	С зэргээр	
2008	27.15		27.15
2009	56.71	38.57	95.28
2010	40.53		40.53
2011	149.78		149.78
2012	116.71		116.71
2013	128.82		128.82
2014	69.96		69.96
<b>Нийт</b>	<b>589.66</b>	<b>38.57</b>	<b>628.23</b>





Зураг 1. Ил уурхайн 2022 оны төлөвлөлт

### 1.8.2. Ил уурхайн хүчин чадал

Төсөл хэрэгжүүлэгч “Фокусметал Майнинг” ХХК нь нөөц нь тогтоогдож батлагдсан MV-012263, MV-015152, MV-021702 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Худаг байшинт, Худаг байшинт-1 төмрийн хүдрийн ордуудыг Монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр уурхайлалтын үйл ажиллагаа явуулж улмаар Монгол Улс, тухайн орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг бүрэн хийж орон нутагт хүлээлгэн өгөхөд онцгой анхаарч ажиллах бөгөөд 2022 онд MV-021702 тоот ашиглалтын тусгай зөвшөрөл бүхий талбайд ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөөд байна.

*Хүснэгт 4. Олборлолтын хүчин чадал*

Ашиглалтын он	Блокын дугаар	Хөрс хуулалт м <sup>3</sup>	Үйлдвэрлэлийн нөөц дэх хүдрийн хэмжээ, т	Дундаж агуулга	Кхд, м <sup>3</sup> /тн
2022 он	ОВ-1	1541416.2	355123.79	31.32	4.34
<b>Нийт</b>		<b>1541416.2</b>	<b>355123.79</b>	<b>31.32</b>	

Ил уурхайн хүрээнд хөрс хуулалтын дундаж коэффициент 1 м<sup>3</sup>/тн байна.

Уурхайн ашиглалтын явцад ил уурхайгаас 16,7 мян.м<sup>3</sup> үржил шимт хөрс, 429,1 мян. м<sup>3</sup> үндсэн хөрс нийт 445,775 мян.м<sup>3</sup> хөрс хуулалтын ажил хийгдэхээр төлөвлөж байна. Хөрс хуулалтын ажлыг экскаватор автосамосвалын хослолоор ухаж тээвэрлэн бульдозерын захлах хэлбэрийн гадаад овоолгод байршуулна.

**1.8.3. Ил уурхайн хүрээ, хязгаар**

Дараах үндсэн хэмжээсүүдийг ашиглан ил уурхайн хязгаарыг тогтоов.

- Ажлын доголын өндөр – 4 м
- Аюулгүйн бермийн өргөн – 4 м
- Ажлын талбайн хамгийн бага өргөн – 40 м
- Доголын хажуугийн өнцөг – 65<sup>0</sup>
- Замын өргөн /хоёр зурвастай/ – 15 м
- Замын налуу – 10%

Ил уурхайн ерөнхий хэмжээс газрын гадаргаар 1446-1406 түвшний хооронд байх ба ил уурхайн нийт гадаргын талбай нь 14га байна. Уурхай нь уртаашаа 385м сунасан, өргөөшөө 105м орчим өргөн байна гэж төлөвлөсөн. Траншейн чигийн нийт урт 418м байна.

**1.8.4. Ашиглалтын технологи, механикжуулалтын бүтэц**

Ил уурхайд ажиллах техникийг сонгохдоо захиалагч компанийн техникийн даалгаварт тулгуурлан төлөвлөлтийг хийсэн.

*Хүснэгт 5.*

*Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн бүрдэл*

Зориулалт	Марк	Нийт
Хөрсний өрөмдлөг	Atlas copco ROC L6H	2
Хүдрийн өрөмдлөг	Atlas copco ROC L6H	
Хөрс ухаж-ачих	XCMG700D - 4.6 м <sup>3</sup>	3
Хүдэр ухаж-ачих	XCMG700D - 4.6 м <sup>3</sup>	1
Хөрсний тээвэр	SDLG MT86 57 тн	24
Хүдрийн тээвэр	SDLG MT86 57 тн	6
Мөргөцгийн засвар ажил	XCMG TY-230	1
Хөрсний овоолгын ажил	XCMG TY-230	

Хүдрийн овоолгын ажил	XCMG ZL50GN	2
-----------------------	-------------	---

### 1.10. Уурхайн ажиллах горим

Уурхайн үйл ажиллагаа нь жилийн дөрвөн улиралд тасралтгүй явагдах бөгөөд олон нийтээр амрах баяр ёслолын хоногуудад ажилласан ажиллагсдын цалинг Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжуудад заасны дагуу нэмж олгохоор тооцсон. Цаг агаараас шалтгаалан саатах, төлөвлөгөөт засвар үйлчилгээ, зөвөөр нүүдэл зэрэг хүчин зүйлүүдийг тооцон уурхай нь бодитоор 315 хоног ажиллах юм.

Уурхайн жилд ажиллах хоногийн тоо:

$$N_{a,x}=365-(N_{3,A}+ N_{y,x,j}+ N_{b,e}+ N_{ц,a}+ N_{3,H}) = 300 \text{ хоног}$$

$$N_{3,A}- \text{Засварт зогсох хоног:} \quad N_{3,A}=21$$

$$N_{y,x,j}- \text{Улирал хагас жилийн зогсолт:} \quad N_{y,x,j}=14$$

$$N_{ц,a}- \text{Цаг агаарын саатал} \quad N_{б}=14$$

$$N_{b,e}- \text{Баяр ёслолын өдрүүдийн амралт} \quad N_{b,e}=9$$

$$N_{3,H}- \text{Зөвөөр нүүдэл} \quad N_{3,H}=7$$

Уурхайн олборлолтын ажмл 2022 оны 11

### 1.11. Гадаад тээвэр

Төмрийн баяжмалыг автомашинаар тээвэрлэн Улаанбаатар хотод байрлах Толгойт өртөө хүртэл тээвэрлэлт хийх бөгөөд баяжуулах үйлдвэрээс УБ хот хүртэл 260 км байх ба ачаа тээврийг гэрээт компаниар гүйцэтгүүлэхээр төлөвлөж, 1 тн/км-ын өртгийг 210 төгрөг байхаар тооцож төсөлд тусгасан.

#### Хүснэгт 6. Гадаад тээврийн зардал

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 он
1	Тээвэрлэх баяжмалын хэмжээ	тн	119,238.71
2	1 тн хүдэр тээвэрлэлтийн өртөг	төг	
3	Тээвэрлэлтийн зай	км	
4	<b>Гадаад тээврийн зардал</b>	сая.төг	6510.4
5	Ковш ачих буулгах зардал	сая.төг	132.9
<b>Нийт</b>			<b>6,643.36</b>

Эцсийн бүтээгдэхүүн төмрийн баяжмалыг Толгойт өртөөнөөс вагонд ачаалан Замын Үүд боомтоор БНХАУ-д экспортод гаргахаар төлөвлөж байгаа эдийн засгийн тооцоонд тухайн чиглэлд тээвэрлэх өртөг зардлыг тооцон гаргасан болно.

#### Хүснэгт 7. Төмөр замын тээврийн зардал

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 он
---	----------	-------------	---------

1	Нийт вагоны тоо	ширхэг	1,834.4
2	Нийт цувааны тоо	ширхэг	183.4
3	Вагон захиалга хуудас /100 төг/	сая.төг	0.2
4	Тээврийн хөлс /1 вагонд 1663.6 мян.төг/	сая.төг	3,051.8
5	Тээвэр зуучийн төлбөр /4448 төг/	сая.төг	530.4
6	Вагон ашиглалт /1 вагонд 50 мян.төг/	сая.төг	91.7
7	Вагоны зам ашиглалт /1 вагонд 20 мян.төг /	сая.төг	36.7
8	Бичиг баримтын хөлс /1 вагонд 5000 төг/	сая.төг	9.2
9	Вагон таталт тавилт сэлгээ /1 вагонд 15 мян.төг /	сая.төг	27.5
10	Вагон пүү /1 вагонд 20 мян.төг/	сая.төг	36.7
	<b>Нийт</b>	<b>сая.төг</b>	<b>3,784.1</b>

*Хүснэгт 8. Гаалийн мэдүүлгийн төлбөр*

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 он
1	Бүтээгдэхүүний хэмжээ	тн	119,238.7
2	Нийт вагоны тоо	ширхэг	1,834.4
3	Нийт цувааны тоо	ширхэг	183.4
4	Бүрдүүлэлтийн хураамж /1 тн 1500 төг/	сая.төг	119.2
5	Төлбөрт үйлчилгээ /1 удаа 8*4 мян.төг/	сая.төг	5.9
6	Мэдүүлгийн үнэ /1 удаа 1200 төг/	сая.төг	0.2
7	Мэдүүлгийн хөлс / 1 удаа 7000 төг/	сая.төг	1.3
	<b>Нийт</b>	<b>сая.төг</b>	<b>126.6</b>

**2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт**

**2.1 Төслийн газарзүйн байрлал**


Булган аймаг нь манай орны төв хэсэгт Орхон Сэлэнгийн сав газарт 48.7 мянган хавтгай дөрвөлжин километр газар нутгийг хамран орших ба тус аймаг нь 15 сум, 75 багтай бөгөөд Хөвсгөл, Сэлэнгэ, Төв, Өвөрхангай, Архангай гэх 5 аймагтай хил залган оршдог. Булган аймгийн Бүрэгхангай сум нь Дархан хайрханы өвөрт орших бөгөөд тус сумын нутгаар Шивэртийн гол дайран өнгөрдөг байна.

Улаанбаатар хотоос 265 км, Аймгийн төвөөс 86 км зайд байрладаг бөгөөд Булган аймгийн Орхон, Хишиг-Өндөр, Дашинчилэн, Төв аймгийн Заамар, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумдтай хиллэдэг.

Бүрэгхангай сум нь нийт 3497.92 км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй, далайн түвшнээс дээш 1000-1100м өргөгдсөн байх ба физик газарзүйн хувьд Булган аймгийн зүүн урд Туулын дэд мужид багтдаг бөгөөд газар хөдлөлийн эрчим 9 балл. Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод

бүхий тал хээр буюу мал аж ахуй болон газар тариалан, аялал жуулчлал эрхлэхэд тохиромжтой.

Монгол орны байгалийн бүс бүслүүрийн ангилалаар тайгын бүслүүр болон ойт хээрийн бүсэд хамаарах бөгөөд төслийн талбайд хээрийн хүрэн хөрс өргөн тархалттай байна.



**Зураг 1. Монгол орны байгалийн бүс, бүслүүрийн зураг**

Төслийн талбайн газрын гадаргын эвдрэл, өөрчлөлт нь газарзүйн байрлал, уур амьсгал, гадаргын онцлогоос ихээхэн хамааралтай. Дулааны улиралд хур борооны ус нь Ү хэлбэрийн олон тооны гуу жалгаар урсах бөгөөд тал хөндийд орж задгайрна. Энэ үйл явцаар хөрсний эвдрэл хүчтэй явагддаг боловч хуурайшилт ихтэй нутгийн хувьд харьцангуй бага давтамжтай. Мөн хавар, намрын улиралд салхины хурд ихтэй байх бөгөөд шороон шуургатай өдөр 27-53 өдөр байдаг. Энэ нь хөрс, ургамлан нөмрөгт сөргөөр нөлөөлж байдаг.

### **2.3. Төсөл хэрэгжих орчны гадаргын болон гүний усны төлөв байдал**

Ордын талбай нь ус зүйн хувьд Төв азийн гадагшаа урсгалгүй ай савын бүсэд багтдаг. Энэ ай савд хур тунадас харьцангуй бага, ууршилт их учраас гол мөрний сүлжээ маш бага бөгөөд нэгж талбайд ноогдох голын нийлбэр урт нь 0.01 км/км<sup>2</sup> -ээс доош байдаг. Эндэх гол мөрдийн үндсэн онцлог бол уулсаас гарангуутаа дотоодын аль нэг хотгор руу чиглэхдээ уурших юм уу, хөвсгөр зузаан хурдсанд шургах замаар ширгэж замхардагт оршино. Тухайн жил, улирлын цаг уур, хур тундасны хэмжээнээс хамаарч усны горим ихээхэн хувьсамтгай, заримдаа гандаж ширгэдэг байна. Гол мөрний нийлбэр урсац 5мм-ээс доош байна. Харин гадаргын урсац нь болон газар доорхи урсац нь 5мм-ээс доош, жилийн дулаан үеийн ууршилт 1000мм-ээс дээш хэмжээтэй. Гол мөрний усны горимын хувьд зуны хур борооны усаар үерлэдэг сайр их тогтдог. Үүнд газар доорхи ус 10%, хур борооны ус 90%-ийг эзэлдэг. Уг сайрууд нь хэдэн зуун метрээс хэдэн арван км үргэлжлэдэг. Цас их орж хайлах, үргэлжилсэн

бороотой үед эдгээр сайрууд урсгалтай болж бороо татрахад усгүй хуурай болно. Шар усны үерийн хамгийн их урсац нь Тост уул орчмоор 10-50мм бусад хэсгээрээ 10-аас доошгүй хэмжээтэй байдаг. Хур бороотой үед жижиг хонхор, хотгор газарт жижиг нуурууд бий болох ба тэдгээр нь элс, булингартай усаар дүүрч, хэдэн долоо хоног, хэдэн сар ч устай байдаг байна. Хүн малын ундаанд худгийн ус хэрэглэх бөгөөд худгуудыг голчлон дөрөвдөгчийн хурдсанд хуурай сайр, нуурын зах хавийг бараадуулан гаргасан байдаг. Худгийн түвшин нь 1-2 метр, заримдаа 5-7 метрт байдаг. Төслийн талбай орших Бүрэгхангай сум нь “Алтайн өвөр говь” усны сав газарт харъяалагдах бөгөөд Мандал-Овоо, Булган, Хүрмэн сумдад Онги гол, Улаан нуурын гадаргын ус, гадаргын усны чанарын 3 харуул ажиллаж байна.

Тухайн талбайд гадаргуугийн урсгал ус байхгүй, зөвхөн хур борооны үед, эсвэл хавар цас хайлах үеэр гуу жалгуудаар түр зуурын горхи урсдаг ба жижиг хонхоруудад түр зууры хугацаанд жижиг нуур цөөрөм үүсдэг боловч удалгүй хатаж ширгэдэг. Ийм учраас дүүргийн хэмжээнд газрын доорх усны тухай яригдаж, судалгаа хийгддэг.

Судлаачид тухайн дүүрэгт 2 төрлийн газрын доорх усны эх үүсвэр ялгадаг.

1. Давхаргын нүх сүвийн ус
2. Анцавын ба давхаргын ан цавын ус

Байршлын нөхцлөөр нь бүх газрын доорх усыг хөрсний ба даралтат ус гэж хуваадаг. Усны тэжээгч эх үүсвэр нь мэдээж атмосферь хур тунадасны шүүрлийн ус юм.

1. Давхаргын нүх сүвийн ус: Энэ нь сэвсгэр хурдаст агуулагдах ус юм. Сэвсгэр хурдас дахь ус агуулагч давхарга нь пролюви-делювийн, салхины хурдсын ба нуурын хурдас бөгөөд тэдгээрийн элс, супесь, хайрга сайргын давхаргууд болдог. Сэвсгэр хурдасны зузаан 1-13 м-т хэлбэлздэг. Энэ төрлийн ус нь тухайн хурдас дотор тодорхой хэсэгт тархалттай ба голдуу хөндий хотгор хэсэгт цуглардаг. Хөрсний усны гүн нь 0-3 м байдаг ба худгууд дахь усны хувийн урсац 1.5 л/с-ээс хэдэн арван л/с-д хэлбэлздэг. Ус нь ерөнхийдөө шорвогдуу амттай.

2. Ан цавын ба давхаргын ан цавын ус: Судалгааны талбайн дүүрэгт энэ төрлийн усыг дотор нь 3 хуваадаг:

- а. Эффүзив чулуулаг дахь ус
- б. Хувирмал чулуулаг дахь ус
- в. Гүний чулуулаг дахь ус

а. Галт уулын гаралтай дээд юра-доод цэрдийн хурдсын ус агуулагч комплекс. Тус хурдсын риолит, риолит-порфирын давхарга нь ус агуулдаг ба ус нь түүн дэхь ан цав, тектоник хагарал бутралын бүс даган байрладаг.

Эффүзив чулуулаг дахь усны давхарга нь хэдэн м-ээс 50-60 м-ийн гүнд байрладаг ба гүнд байрлах ус нь даралттай байдаг. Ус нь цэвэр тунгалаг, 0.15-1.0 г/л эрдэсжилттэй. Химийн

найрлагаараа гидрокарбонат-натрийн, кальци-натрийн, хлорид-натрийн гэж ангилагддаг, ерөнхий хатуулаг нь 0.53-3.9 мг/экв.

б. Гантигжсан шохойн чулуу нь илүү их ан цавтай, зарим хэсэгтээ карст үүсгэдэг тэдгээртээ ус агуулдаг байна. Гэхдээ энэ насны хурдсын усжилт их биш, худгийн усны ундарга нь 0.1-0.3 л/с-д хэлбэлзэнэ. Ус нь давсархаг амттай, гидрокарбонат-хлорид-натрийн ба гидрокарбонат-натри-кальцийн бүлэгт хамаарна. Ерөнхий хатуулаг нь 2.4-8 мг/экв.

в. Доод ба дээд палеозойн гүний чулуулгийн ус. Талбайн хэмжээнд гүний чулуулаг ихээхэн тархалттай, түүний дотор боржин чулуу голлодог. Бүхий л гүний чулуулгууд ан цавшилт ихтэй, тэдгээрээс тектоник эвдрэл, цавшилттай хэсэг нь илүүтэй ус агуулдаг.

Гүний чулуулаг дахь газрын доорх ус нь энэ чулуулгийн ан цав ихтэй өгөршсөн гадаргууд ойрхон хэсэгт ба тектоник эвдрэл цуурлууд даган нилээд гүн байрлалтай байдаг. Эдгээр гүний чулуулагт агуулагдах усны түвшин гадаргуугаас 0.5-30 м-ийн гүнд оршдог. Ундарга багатай, хамгийн их ундарга нь 0.1-1.0 л/с-д хүрдэг. Ерөнхий хатуулаг нь 13.28 мг/экв. Усны найрлага нь гидрокарбонат-натрийн ба магни-кальцийн ангилалд хамаарна.

#### **2.4. Төсөл хэрэгжих орчны хөрсөн бүрхэвч**

Тухайн талбай нь Монгол орны хөрсний ангилалаар Уулын, Уулын хээрийн хэв шинжийн, Уулын ердийн харшороон ба ердийн хархүрэн хөрсний төрөлд хамаарагдана.

Энэ хэв шинжийн хөрс Хангай, Хэнтийн нурууны зах уулс, монголын төв, дорнод хэсгийн бэсрэг уулс, Монгол Алтай, Говь-Алтайн нуруу, Хархираа, Түргэний уулст үргэлжилсэн бүс, дэд бүсүүд үүсгэх бөгөөд тархалтын хувьд манай орны уулын хөрсүүд дотроос хамгийн өргөн дэлгэрсэн нь юм. Уулын хүрэн шороон хөрсний нийт талбай улсын бүх нутгийн 22.4%-ийг эзэлнэ. Энэ хөрсний байрлах үнэмлэхүй өндрийн доод түвшин нь 80—900 м, дээд түвшин нь төв, дорнод хэсгээр 1700-1800м, Монгол Алтай, Говь-Алтай, Хангайн баруун, баруун өмнөт хэсгээр 2500-2600м хүрнэ. Үетэн голлосон хуурай хээрийн ургамалшил зонхилж шигүү сийрэг нь 25-30% - иас 60-70% хүртэл хэлбэлзэнэ. Эдгээр хөрс өвлийн улиралд 1.5-2.5м хүртэл гүн хөлдөж хавар – зуны эхэн үед түргэн гэсдэг тул хур борооны үеэр хөрсөнд улиралын цэвдэг байдаггүй. Уулын хар шороон хөрстэй адил үе үе нэвт норж угаагдах чийгийн горим зонхилох боловч уулын өвөр хажуу дээрх сайр чулуурхаг нимгэн хөрс жил бүр нэвт норж (тэр ч байтугай зарим жил ургамлын ургалтын хугацаанд хэдэн удаа нэвт чийглэгдэж) угаагдлын чийгийн горимтой байдаг тохиолдол ч бий. Үүнээс болоод уулын хүрэн шороон хөрсний дотор карбонатгүй хөрс бас цөөнгүй тохиолддог.

Уулын хажуугийн зүг зовхис, эгц хажуугийн байдлаас хамаараад хөрсний тогтворжилт харилцан адилгүй байна. Уулын хажуу эгц болох тутам элэгдэл эвдрэлийн явц

хүчтэй илэрч, хөрсний үе давхаргууд нимгэрч, хоорондын ялгаа зааг нь бүдгэрч, сул сайр чулууны агуулагдах хэмжээ нэмэгдэнэ. Уулын ар, өвөр хажуугийн хөрс хоорондоо ялгаатай байдаг нь бичил уур амьсгалын нөхцөл өөр байдгаас багагүй шалтгаалдаг.

Уулын өвөр хажуу ар хажууг бодвол нарны цацрагийн тусгал ихтэй учраас өдрийн цагаар сайн халж, шөнөдөө температур нь эрс буурдаг. Хоногийн температурын хэлбэлзэл байнга их, эрс тэс шинжтэйгээс шалтгаалж уулын суурь чулууны хагарч бутрах үйл явц эрчимтэй явагдаж элюви, делювийн их сайр чулуурхаг хурдас үүсэх нөхцөл бүрдэж улмаар урагшаа харсан хажуу голдуу эгц өнцөгтэй, их чулуурхаг байна. Энэ учраас ургамлан бүрхэц сийрэг (20-40%), хөрс нь элэгдэлд өртсөн, бүдүүн ширхэгтэй тоос шороо, чулууны хэмхдэс ихтэй, ялмагийн давхарга болон бүх үе давхарга нь нимгэн байдаг онцлогтой. Уулын өвөр хажуугийн сайр чулуурхаг нимгэн хүрэн шороон хөрсний профильд карбонатын хуримтлалын давхарга сайн илэрдэггүй, түүгээр ч барахгүй бүр карбонатгүй байх нь цөөнгүй тохиолддог. Тэхдээ түүнээс доошхи бэл хормойн хөрс карбонатын хуримтлал ихтэй байдгаас харахад уулын өвөр хажуугийн хөрсний карбонат гадаргийн болон хөрсөн доогуурхи урсацаар угаагдаж газрын уруу зөөгддөг нь тодорхой байна.

## **2.5. Төсөл хэрэгжих орчны ургамлан нөмрөг**

Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт байрлах төмрийн хүдрийн ордын талбай нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Евразийн хээрийн муж, Хангайн уулын ойт хээрийн провинц, Умард Хангайн уулын ойт хээрийн тойрог, Орхон-Туулын районд хамаарагдана.

Энэ газрын гадарга нь ерөнхийдөө хойшоо налуу тогтоцтой, эндхийн уул нурууд нь 1000-1700 м өндөрт өргөгдсөн уулын хуурай хээр бүсэд багтана. Ургамлын нөмрөг бүрхэц харьцангуй сайн 80%-ийн бүрхэцтэй 1 га-ийн жилийн дундаж ургац 2.5-3.0 ц/га, жилийн дөрвөн улиралд бүх төрлийн малд тохирох сайн чанарын бэлчээртэй, үетнээс Крыловын хялгана, Ленийн ботууль, Хиаглай түнх, Саман ерхөг, Хазаар өвс, Үлд өвс, Ганга өвс, Толгодын багваахай цэцэг, Дэрвэн дэгд зэрэг ургамал зонхилно. Ургамлын 1м<sup>2</sup> талбайн ерөнхий тусгац 40-60%, ургамлын өндөр 25-41 см, бүх төрлийн малд тохирох сайн чанарын ургамалтай. Ургамлын тусгаг бүрхэц 70-80%, ургамлын дундаж өндөр 23-25 см байна.

Гуу жалгыг даган зөөврийн янз бүрийн ургамал ургадаг. Зонхилох ургамал нь хайрст цахилдаг, нарийн навчит харгана, талын харгана, цагаан дэрс, адамсын шарилж, саман ерхөг, хялгана, хазаар өвс, модлог ургамлаас хайлаас зэрэг голчлон ургана.

Бүрэгхангай сумын нутагт гүзээлзгэнэ, улаалзгана, хад, үхрийн нүд, нэрс мойл, бөөрөлзнөнө, долоолгоно зэрэг жимсүүд, самар, олон төрлийн мөөг ургахаас гадна, алтан



гагнуур, бамбай, мэхээр, таван салаа, цээнэ зэрэг 20 гаруй төрлийн эмийн ургамал ургадаг байна.

## **2.6. Төсөл хэрэгжих орчны амьтны аймаг**

Хутаг байшинт төмрийн хүдрийн орчмын нутаг дэвсгэрт 21 зүйлийн хөхтөн амьтан, 119 орчим зүйлийн шувуу, 1 зүйлийн мөлхөгч, 2 зүйлийн хоёр нутагтан тус тус бүртгэгджээ. Хөхтний зүйлийн бүрэлдэхүүний 80 гаруй хувь нь шавж идэштэн, туулай хэлбэртэн, мэрэгч зэрэг жижиг хөхтөн юм. Жижиг хөхтөн тус нутгийн амьдас нийцэд (биоценозод) нэн чухал өргөн оролцоо холбогдолтой. Төсөл хэрэгжих орчимд хийсэн судалгаагаар 140 зүйл шувуу бүртгэгжээ. Энэ нутагт оршин амьдрах амьтдаас Дагуурын зараа, Хар өрөвтас, Хээрийн галуу, Явлаг сар Монгол улсын улаан номонд орсон зүйлүүд болно.

Төсөл хэрэгжих орчмын районд тоо толгойн хувьд хэт олширдог шавж, мэрэгчдийг идэж цөөрүүлдэг 10 зүйлийн хөхтөн, 80 орчим зүйл шувуу байдаг. Байгалийн тэнцвэрт байдлыг зохицуулдаг дээрх амьтдын үзүүлж буй ач тус асар их байдаг нь ойлгомжтой. Ашигтай эдгээр амьтдыг хамгаалах, үржин олшрох нөхцөлийг сайжруулах ажил зохиох нь чухал байна.

Мөн тус нутагт монгол орны хоёр нутагтны ангиас 1 багийн 1 зүйл, мөлхөгчдийн ангиас 2 багийн 2 зүйл амьтан тархдаг. Тус нутагт хөхтний бүлгэмдэлд багтах сахалт багваахай, Дагуур огодой, Монгол тарвага, сүүлт зурам, Дагуур зурам, Монгол огодой, Үлийн цагаан оготно зэрэг хөхтөн амьтад тархжээ. Хоёр нутагтан, мөлхөгчидийн хувьд Рашааны могой, Бамбай Хоншоорт могой, Монгол гүрвэл зэрэг амьтад тархсан.

## **2.7. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн тусгай хамгаалалттай газар нутаг**

Монголчууд эрт дээр үеэс байгалийн үзэсгэлэнт газар, ховор амьтнаа дархлан хамгаалж, онголон тахиж ирсэн өнө эртний хосгүй уламжлалтай билээ. Энэ асуудлыг төрийн бодлогодоо тусгаж өндөр ач холбогдол өгдөг байсны илрэл нь Чингэс хааны “Их засаг” хууль, Ойрадын цааз болон 16-р зууны үеийн хууль цаазат бичиг “Халх журам” зэрэг Монгол улсын хууль тогтоомжуудад нарийн тусгасан явдал юм. Төсөл хэрэгжих “Фокус метал майнинг” ХХК-ийн Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг дэвсгэрт орших “Худаг байшинт” нь Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн бүсчлэлд хамааралгүй болно.

## ХОЁР. 2022 ОНЫ АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Манай компани 2008-2014 онд үйл ажиллагаа явуулж байгаад дэлхийн зах зээлд төмрийн ханш унасанаас шалтгаалан зогссон. 2022 оноос үйл ажиллагаа явуулж эхлээд байна.

Энэ онд 35 мянган тн төмрийн баяжмал боловсруулан гаргаж, 10 мянган тн баяжмал тээвэрлэх ажил хийгдээд байна.

Уурхайн ашиглалтыг ил аргаар 2008-2014 онд үүссэн хаягдал чулууг дахин ашиглаж нойтон баяжмал боловсруулан гаргасан.

**Баяжуулалтын технологи, боловсруулалт.** Уурхайгаас ирсэн анхдагч төмрийн хүдрийг хүдэр хүлээн авах талбайд хуримтлуулах бөгөөд тухайн талбайд буулгагдсан өөр өөр шинж чанар, агуулга бүхий анхдагч хүдрийг аль болох хольж нэгэн жигд шинж чанар, агуулгатай болгон үйлдвэрт тэжээх ба анхан шатны цехид ZL 50 маркийн утгуурт ачигч ашиглах тэжээнэ.

Анхан шатны бутлуурын цех-1-ийн бункер нь 9 м<sup>3</sup> багтаамжтай бөгөөд өгөгдсөн хүдрийг PE900\*1200 маркийн анхан шатны том хацарт бутлуурт өгөгдөнө.

Баяжуулах үйлдвэрийн хүдэр хүлээн авах талбайд хуримтлагдсан 0-600 мм-ийн хүдрийг туузан дамжуулагчаар Mesto брэндийн GP100S маркийн 2 ширхэг конусан бутлуурт өгөгдөнө.

Конусан бутлуурт өгөгдсөн -25 мм-ийн ширхэглэлтэй болтол бутлагдах бөгөөд бутлагдсан хүдэр нь туузан дамжуулагчаар зөөвөрлөгдөн GZG21620 маркийн доргиурт шигшүүрт өгөгдөн ангилагдаж, -25+0 мм болон ширхэглэлтэй болох ба шигшүүрийн дээд бүтээгдэхүүн /-25 мм/ нь конусан бутлуурт дахин өгөгдөн бутлагдана. -25 мм-ийн хүдэр нь 150 м<sup>3</sup>-ийн эзэлхүүн бүхий дундын агуулах хуримтлагдах бөгөөд тус агуулахаас тэжээгүүрийн тусламжтайгаар нойтон аргын технологи бүхий үйлдвэрийн тэжээлийн үндсэн туузан дамжуулагчид өгөгдөнө.

Туузан дамжуулагчаар зөөвөрлөгдөн ирсэн хүдэр бөмбөлөгт тээрэмд өгөгдөн нунтаглагдана. Бөмбөлөгт тээрэмээс гарсан булинга нь өөрийн урсгалаар мушгиа ангилагчаар дамжин тээрэм-1-д дахин өгөгдөж нунтаглагдах бол халиа нь үндсэн баяжуулагчийн нойтон сеператорт өгөгдөн баяжигдана. Үндсэн баяжуулалтын хаягдал нь шууд технологийн хаягдал болж хаягдах бол баяжмал нь хяналтын шигшүүрт өгөгдөж

ангилагдах бөгөөд шигшүүрийн дээд бүтээгдэхүүн соронзон сеператорт баяжигдан бөмбөлөгт тээрэм-2-д өгөгдөн гүйцээн нунтаглагдана.

Хяналтын шигшүүрийн тороор нэвтэрсэн нарийн ширхэг бүхий булинга нь цэвэрлэгээний 2 шатны соронзон сеператоруудад өгөгдөн баяжигдаж, төмрийн баяжмал болон хаягдал гэсэн 2 бүтээгдэхүүн бий болдог. Цэвэрлэгээний 2 шатны нойтон соронзон сеператорын баяжмал нь насосын тусламжтайгаар вакум фильтерт өгөгдөн усгүйжих бөгөөд эцсийн бүтээгдэхүүн баяжмалын чийг 10 %-тай гарах юм. Хаягдал ус өөрийн урсгалаар урсан хаягдал хадгалах санд оруулан цэвэршүүлж, үйлдвэрийн технологид дахин татан авч ашиглаж байна.

**Цахилгаан хангамж.** Үйлдвэрийг эрчим хүчээр хангах зураг төслийг “Эрдэнэт Булган цахилгаан түгээх сүлжээ” ХК-ийн “Эрчим корпораци”-д хийж гүйцэтгэлээ. Уг төсөлд Бүрэгхангай сумын 35/10 кВ-ын “Бүрэгхангай” дэд станцын 35 кВ талыг элегаз таслуур бүхий шугамын ячейкаар өргөтгөл хийж тус станцаас 34,1 км АС-70 дамжуулагч утастай 35 кВ-ын ЦДАШ барьж 1000 кВ чадалтай 35/6 кВ-ын “Хүдрийн уурхай” бууруулах дэд станцыг баяжуулах фабрикт, үйлдвэрлэлийн талбай орчим байгуулсан.

**Усан хангамж.** Баяжуулах үйлдвэрийн усны хэрэглээг хангахын тулд 14,3 км зайд байрлах Туул голын эрэг дээр ус шахах насосын байгууламж байгуулж, баяжуулах үйлдвэр хүртэл ус дамжуулах шугамыг байгуулаад байна. Унд ахуйн усны хэрэглээг уурхайд байрлах гүний худгийн усаар хангаж байна.

Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор үйлдвэрийн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг ашиглалтын нууранд хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашигладаг.

## ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 3.1 Агаар орчныг хамгаалах

Төмрийн хүдрийн ордыг ашиглах явцад их хэмжээний нутаг дэвсгэрийг хамарсан хүн, амьтан, ургамал, хөрс, усанд нөлөөлөхүйц хэмжээний агаарын бохирдол үүсэхгүй юм. Харин уулын ажлын үед /хөрс хуулах/ тоос үүсч болох юм. Энэ нь ордод харьцангуй бага байхын дээр тус нутагт дулааны улиралд хур тунадасны ихэнх нь унах тул эрүүл мэндэд нөлөөлөл багатай. Зам, талбайд Дамп маркын автомашинаар тээвэр явах бүрт усалгаа хийж тоосжилтыг дарах ажил хийгдсэн.

Үйлдвэрийн технологийн замыг цаг агаар, баяжмалаас хамааран 4-р сараас 11-р сар хүртэл өдөрт 3-5 удаа усалгаа хийдэг. Энэ онд 5-р сараас 9-р сарын хооронд дотоод тээвэрлэлт хийх бүрт усалгааны ажил хийгдсэн.



*Авто замын усалгаа*

Уурхайн авто зам, зогсоолд хайрган хучилт хийж, тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан.



*Уурхайн авто зам, зогсоол*




*Төмрийн хүдрийн тээврийн зам засварын ажил*

### **3.2 Хөрс хамгаалах**

**Шимт хөрс.** Зам засах ажлаас гарсан үржил шимт хөрсийг Монгол улсад мөрдөгдөж буй “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS 5916:2008 стандартын дагуу овоолгийг хадгалаж байна.

**Хөрс хуулалт:** 2022 онд хөрс хуулалт хийгдээгүй.



*Газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, ГЗБГЗЗГ-аар батлуулсан.*

Автомашин хүнд механизмаар олон салаа зам гарган хөрсний эвдрэл элэгдэл үүсдэг. Үүнийг багасгахын тулд машин механизмыг тогтсон нэг замаар явуулж замын тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан.







*Замын тэмдэг, тэмдэглэгээ*

Хог хаягдалын гэрээг сумын ЗДТГ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Хог хаягдлыг ангилан ялгаж, сумын хогийн цэг тээвэрлэн хаяж байна. Ахуйн хогийн цэгийг хөрсний бохирдолоос сэргийлж ариутгалын сард нэг удаа хийж байна. Хаягдал тос, масло түр хадгалах цэг байгуулан хадгалж байна.



*Ангилан ялгах хогийн сав*

Хөрс тос, маслоор бохирдохоос сэргийлж бетонон хучилт хийсэн засварын талбайд техникийн засвар үйлчилгээг хийж байна.



*Засварын талбай*

### 3.3 Усан орчныг хамгаалах

Усны газрын 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 145 дугаар ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн Туул голын сав газрын захиргааны даргын 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулан ажиллалаа.

Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор үйлдвэрийн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг ашиглалтын нууранд хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашигладаг.



*Эргэлтийн усан сан*

Туул голоос ус татах 2-р насосын 2 шугам дээр тус бүр 1 ширхэг усны тоолуурыг суурилуулан усны нөөцийг хэмнэлттэй ашиглаж байна.



*Усны тоолуур*

Төмрийн хүдэр баяжуулахад ашигласан 10803 м<sup>3</sup> гадаргын ус ашигласны төлбөрт 2577488 төгрөг, ус бохирдуулсны төлбөр 704380 төгрөг тус тус Булган аймгийн Төрийн сангийн дансанд төлөөд байна.

### **3.4 Ургамлан нөмрөг хамгаалах**

Захцаг уул, Худаг байшинтын орд нь Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэг, Орхон голын баруун цутгал болох Туул голын хөндийн Баруун Захцаг уулын бэлд байрладаг.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн 2030 он хүртэл 200000 мод тарих батламж аймгийн Засаг даргаас гардан авлаа. 2022 онд 1300 улиас, 1200 бургас зэрэг нийт 2500 мод тарилаа.



*Намрын мод тарилт*

Хаягдлын усны санд мал, амьтан орохоос сэргийлж хамгаалалтын хашаа барилаа.



*Хаягдал усан сангийн хамгаалалтын төмөр торон хашаа*

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Гүйцэтгэл	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох Хүдэр, хаягдал чулуу тээвэрлэх, ачих, буулгах үед үүсэх тоосжилт Тэсэлгээний ажлын үед үүсэх тоосжилт	Тээвэрлэлтийн үед гарах тоос шороог багасгах үүднээс уурхайн дотоод болон гадаад зам талбайг хусаж цэвэрлэх	Уурхайн дотоод ба гадаад тээврийн зам	Уурхайн дотоод зам, зогсоолын талбайд дайргаар хучилт хийж зассан. Уурхайн гадаад замын эвдэрсэн хэсгүүдэд дайргаар дүүргэх тэгшлэх ажлыг хийж байна.	БОС-ын 1995 оны 153 тоот тушаал
	Хүнд машин механизмын утааны хэмжээг стандартын шаардлага хангах, засвар үйлчилгээг тогтмол хийх	Уурхайн бүх машин механизм	Хүнд машин механизмын утааны хэмжээг стандартын шаардлага хангах, засвар үйлчилгээ, тос масло, шүүр солих ажлыг хугацаанд нь тогтмол хийж байна.	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
Ажиллагсадын эрүүл мэндэд нөлөөлөх	Уурхайн ажиллагсдад амны маскаар хангах, сургалт сурталчилгаа явуулах	Уурхайн бүх ажилчид	Уурхайн ажилчдад зориулалтын амны хаалтаар өдөр бүр хангаж, эрүүл мэндийн сургалт сурталчилгааг тогтмол хийж байна.	MNS13688:2000 MNS5620:2006 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004
Төслийн үйл ажиллагаагаар хөрс хими, физикийн бохирдолд орох.	ШТМ-ын хаягдлыг хадгалах битүүмжлэл сайтай сав бэлтгэх	ШТС, засвар механикийн цех орчим	Шатах тослох материалын хаягдлыг битүүмж сайтай саванд хийж, түр хадалгах түр хадгалах байранд хадгалж байна.	



“ФОКУС МЕТАЛ МАЙНИНГ” ХХК

Шатах тослох материал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Хөрсөнд шатах тослох материал асгарсан үед ашиглах саармагжуулах бодис хадгалах	Засвар механикын цех, ШТС-ын орчим	Хөрсөнд шатах тослох материал асгарсан үед хөрсийг хусах бөгөөд шингээж авах элс, хайрга бэлтгэсэн.	MNS 3307:1991
Шатах тослох материал, ахуйн шингэн хаягдал алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтанд сөргөөр нөлөөлж болзошгүй.	Ахуйн бохир ус зайлуулах цэгийг шинээр байгуулах	Уурхайн хотхон орчим	Ахуйн бохир зайлуулах 15 м <sup>3</sup> эзэлхүүнтэй соруулдаг танк хийн газарт суурилуулаад байна.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль MNS 4288:1995
	Ус ашиглалтын гэрээний дагуу ус ашигласны төлбөр төлөх	-	Төмрийн хүдэр баяжуулахад ашигласан 10803 м <sup>3</sup> гадаргын ус ашигласны төлбөрт 2577488 төгрөг, ус бохирдуулсны төлбөр 704380 төгрөг тус тус Булган аймгийн Төрийн сангийн дансанд төлөөд байна.	
Усны нөөц хомсдох	Төслийн нөлөөллийн бүсд байрлах уст цэгүүдэд хэмжилт хийж хяналт тавих	Уурхайн гүний худаг	Уурхайн ундны усанд 2 удаа шинжилгээ хийхэд ундны усны стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байна.	
Нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах	Дуу шуугианы хэмжилт хийж, дуу, шуугиан бүхий машин механизмийн ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгах	Уурхайн олборлолтын талбай	Машин механизмийн ашиглалтын төлөвлөж засвар үйлчилгээний ажлын тогтмол хэрэгжүүлж байна.	

**ДӨРӨВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Гүйцэтгэл	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Төслийн хаалт, нөхөн сэргээлтэд ашигалх хөрсийг бэлгэх	Гадаад овоолгыг төлөвлөлтийн дагуу байгуулах бэлгэл ажил	Уурхайн гадаад овоолго	Тайлант онд 2008-2014 онд үүссэн хаягдал хүдрийг дахин баяжуулсан бөгөөд хөрс хуулалтын ажил хийгдээгүй болно.	“Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээлт хийх аргачлал” “Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн мэдээний маягт-Бох-3”
	Шимт хөрсний овоолгыг төлсний хаалтад ашиглахад бэлгэх байдлаар төлөвлөлтийн дагуу байгуулахад бэлгэх	Шимт хөрсний овоолго	Тайлант онд 2008-2014 онд үүссэн хаягдал хүдрийг дахин баяжуулсан бөгөөд хөрс хуулалтын ажил хийгдээгүй болно.	
	Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах ургамлуудыг сонгох ирэх оны шимт хөрсний овоолгыг ургамалжуулах ажилд бэлтгэх	Уурхайн хотхон ирэх онд хэрэгжүүлэх биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг боловсруулах, дулааны улирал тариаллах ургамлын сонголтын хийх	Уурхайн хотхоны ногоон байгууламжид зориулж мод үржүүлгийн газарт 500 ш шар хуайс үржүүлж байна.	

**ТАВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**



*Орон нутгийн иргэдэд ногоон тэжээл тарааж байгаа нь*

**Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Гүйцэтгэл	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Орон нутагт тулгамдаж буй байгаль орчны асуудалд хамтран ажиллаж дэмжлэг үзүүлэх.	Төслийн талбай нь өмнө бэлчээрийн зориулалттай байсан тул орон нутгийн	Бүрэгхангай сум	Уурхайн ойр орчмын 32 айл өрхөд тус бүр 10 боодол ногоон тэжээл тараах ажлыг хэрэгжүүллээ.	Биологийн олон янз байдлыг хамгаалах үндэсний хөтөлбөр

	бэлчээрийн мал аж ахуйн өвлийн улиралд өвс, тэжээл өгөх ажлыг хийнэ.			
--	--	--	--	--

**ЗУРГАА. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул 2022 оны БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

**ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Гүйцэтгэл	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Одоогоор газрын газрага дээр түүх соёлын өв байхгүй	Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.	Олборлолтод өртөх талбай	Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдоогүй болно.	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014/

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Гүйцэтгэл	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Нийт төсөл хэрэгжих талбай	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгаж, машин техникийн үйлчилгээ, засварыг засварын бетонон хучилттай талбайд хийж байна.	Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1,  Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм  Тэсэлгээний аюулгүй ажиллагаа
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Уурхайн бүх ажилчдад	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний сургалтыг уурхайн ажилчдад 2 удаа зохион байгууллаа.	
	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөг боловсруулан батлуулах.	Үйл ажиллагааны турш	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.	
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Үйл ажиллагааны турш	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлыг ангилан ялгах сургалтыг уурхайн ажилчидад 2 удаа зохион байгуулж, тогтмол мэдээлэл зөвлөмж өгч ажиллаж байна. Мөн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, сумын ЗДТГ-ын холбогдох албан хаагчидтай нийт 12 удаа уулзаж, зөвлөгөө мэдээлэл авч, харилцан санал солилцож ажиллалаа.	
Ашиглаж буй тэсрэх материалын хор, аюулын талаарх анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тухай тэмдэглэгээг ажлын байранд харагдахуйц байрлалд самбар тэмдэглэгээ байрлуулах	Үйл ажиллагааны турш	Тэсрэх материалын хор, аюулын талаарх анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тухай тэмдэглэгээг хадгалах цэгт, сурталчилгааны материалыг ажлын байранд байршууллаа.		

ЕС. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ



*Дахин ашиглах хог хаягдлын түр хадгалах цэгүүд*

Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Гүйцэтгэл	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хатуу хог хаягдлыг цуглуулж нэгдсэн цэгт хүргэж устгаж байх	Уурхайн хотхон	Бүрэгхангай сумын ЗДТГ-тай хог хаягдлын гэрээ байгуулж, сумын нэгдсэн хогийн цэгт хог хаягдлыг тээвэрлэн хүргэж байна.	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд  Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай болгох, ангилсан хогийн сав байршуулах	Уурхайн хотхон	Хог хаягдлыг зориулалтын болон ангилан ялгах тагтай сав байрлуулсан.	
	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж саармагжуулах	Засварын цех	Хаягдал ажилласан тосыг бүтүүмж сайтай саванд хийж түр хадгалах цэгт хадгалж байна.	
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Уурхайн хүрээнд	Хог хаягдлын төрөл, хор уршиг, ангилан ялгах талаар уурхайн ажилчидад сургалт зохион байгуулж тогтмол зөвлөгөө өгч ажиллаж байна.	
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Шингэн хаягдлыг тусгай бодис хэрэглэн задлан шингээх	Уурайн хотхон, засварын цех	Шингэн хаягдал хуримтлуулах соруулдаг 15 м <sup>3</sup> эзэлхүүнтэй танк суурилуулан ашиглаж байна.	

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

БУЛГАН АЙМГИЙН УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ХАРЪЯА БАЙГАЛ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Булган аймгийн Бүрэгхангай суманд үйл ажиллагаа явуулж буй  
"Фокус металл майнинг" ХХК-ний орчны хяналт шинжилгээний дүн  
Усны шинжилгээ хийсэн дүн

Дээжийн нэр ..... ундны ус .....  
Дээжийн хэмжээ ..... ус- 1,0 литр .....  
Дээжийн дугаар ..... № 03 .....  
Дээж ирүүлсэн газрын нэр ..... "Фокус металл майнинг" ХХК .....  
Дээж авсан газрын нэр ..... Булган аймгаг Бүрэгхангай сум .....  
Дээж авсан хүний нэр, албан тушаал ..... "Фокус металл" ХХК-ний уурхайн дарга .....  
Шинжилгээ эхэлсэн огноо ..... 2022.05.20 .....  
Шинжилгээ дууссан огноо ..... 2022.05.30 .....  
Шинжилсэн аргачлал ..... Ундны усны стандарт. MNS 0900:2018

№	Шинжилсэн үзүүлэлт, хэмжих нэгж	MNS 0900:2018 Зөвшөөрөгдөх агууламж	Шинжилгээний дүн
1	pH-Усны орчин	6.5-8.5	7.56
2	Ес-цахилгаан дамжуулах чанар, μs/cm	1	0.92
3	Нийт хатуулаг, мг-экв/л	7.0	3.63
4	Кальци, мг/л	100.0	39.3
5	Магни, мг/л	30.0	25.2
6	Натриг+Кали, мг/л	200.0	55.5
7	Хлорид, мг/л	350	21.3
8	Нитрат, мг/л	9.0	0.076
9	Нитрит, мг/л	0.020	0.022
10	Аммоний, мг/л	1.5	0.26
11	Төмөр, мг/л	0.3	0.29
12	Фосфат, мг/л	0.1	0.037
13	Сульфат, мг/л	100	85.8
14	Гидрокарбонат, мг/л	-	146.4
15	Эрдэсжилт	-	224.1
16	Фтор	0.7-1.5	1.2

Шинжилгээ хийсэн: УЦУОШТ БОШЛ-ын техници Т.Түмэнжаргал  
Хянасан: УЦУОШТ БОШЛ-ын ахлах инженер М.Насанжаргал



БУЛГАН АЙМГИЙН УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ХАРЪЯА БАЙГАЛ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Булган аймгийн Бүрэгхангай суманд үйл ажиллагаа явуулж буй  
"Фокус металл майнинг" ХХК-ний орчны хяналт шинжилгээний дүн  
Агаар, хөрсний шинжилгээ хийсэн дүн

Дээжийн нэр ..... агаар, хөрс .....  
Дээжийн хэмжээ ..... хөрс- 1,0 кг .....  
Дээжийн дугаар ..... № 03 .....  
Дээж ирүүлсэн газрын нэр ..... "Фокус металл майнинг" ХХК .....  
Дээж авсан газрын нэр ..... Булган аймгаг Бүрэгхангай сум .....  
Дээж авсан хүний нэр, албан тушаал ..... "Фокус металл" ХХК-ний уурхайн дарга .....  
Шинжилгээ эхэлсэн огноо ..... 2022.05.20 .....  
Шинжилгээ дууссан огноо ..... 2022.05.30 .....  
Шинжилсэн аргачлал ..... Агаар. MNS 4585:2016, Хөрс MNS 5850 : 2008

Агаарын шинжилгээ

А/А	Дээж авсан цэг	SO <sub>2</sub> мг/м <sup>3</sup>	NO <sub>2</sub> мг/м <sup>3</sup>
1	Фокус металл камп орчмын агаар	0.003	0.019
2	Хүлцэх агууламж	0.450	0.200


Дүгнэлт: Шинжилгээний дүнг MNS 4585:2016 стандартай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт гарвагүй байна.

Хөрсний шинжилгээ

А/А	Сорьц авсан цэг	Чийг %	pH	NH <sub>4</sub> мг/кг	NO <sub>3</sub> мг/кг	SO <sub>4</sub> мг/кг	K <sub>2</sub> O мг/кг	P <sub>2</sub> O <sub>5</sub> мг/кг	Pb мг/кг	Cu мг/кг	Cd мг/кг
1	Карьерын өнгөн хөрс	31	7.63	27.1	27.6	79.8	18.5	3.57	21.2	20.2	0.17
2	Үйлдвэрийн өнгөн хөрс	35	7.94	33.2	59.6	67.8	22.1	0.39	35.2	22.4	0.59
3	Шатахуун түгээх газар	29	7.96	31.3	55.2	106.4	17.2	3.22	33.1	37.6	0.64
4	Хүлцэх агууламж	-	-	-	-	-	-	-	100	100	3

Дүгнэлт: Хөрсний шинжилгээг MNS 5850 : 2008 стандартай харьцуулан хийхэд уг хөрс нь хөнгөн шарванцар механик бүрддэхүүнтэй, хөдөлгөөнт фосфорын агууламж 0.39-3.57 мг/кг хөдөлгөөнт кали 18.5-22.1 мг/кг, бохирдол хэвийн хэмжээнд байна.

Шинжилгээ хийсэн: УЦУОШТ БОШЛ-ын техници Т.Түмэнжаргал  
Хянасан: УЦУОШТ БОШЛ-ын ахлах инженер М.Насанжаргал



БУЛГАН АЙМГИЙН УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ХАРЪЯА БАЙГАЛЬ ОРЧИН ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт үйл ажиллагаагаа явуулж байгаа "Металл Майнинг" ХХК-ний орчны хяналт шинжилгээний гадаргын усны дүн

Дээжийн хэмжээ ..... Ус-1.5л .....  
Дээжийн дугаар ..... № 7 .....  
Дээж ирүүлсэн газрын нэр ..... "Фокус металл майнинг" ХХК .....  
Дээж авсан газрын нэр ..... "Хагдалын сангийн ус" .....  
Шинжилгээ эхэлсэн огноо ..... 2022.08.10 .....  
Шинжилгээ дууссан огноо ..... 2021.08.17 .....  
Шинжилсэн стандарт арга ..... MNS ISO 6561 : 2015

Шинжилгээний үр дүн

№	Шинжилсэн үзүүлэлт, хэмжих нэгж	MNS ISO 6561:2015 Зөвшөөрөгдөх агууламж	Шинжилгээний дүн
			Хагдалын сан
1	pH-Усны орчин	6.5-9.0	7.29
2	Ес-цахилгаан дамжуулах чанар, μs/cm	-	270.6
3	Хатуулаг, мг-экв/л	7.0	2.39
4	Кальци, мг/л	100.0	33.5
5	Магни, мг/л	30.0	8.8
6	Натриг+Кали, мг/л	200.0	24.8
7	Хлорид, мг/л	300	2.1
8	Нитрат, мг/л	9.0	0.85
9	Нитрит, мг/л	0.020	0.019
10	Аммоний, мг/л	1.5	0.36
11	Төмөр, мг/л	3.0	0.015
12	Фосфат, мг/л	1.5	0.053
13	Сульфат, мг/л	700	34.6
14	Гидрокарбонат, мг/л	-	158.6
15	Жинлэгдэх бодис	400	36.0
16	Эрдэсжилт	-	259.4
17	Фтор	1.5	0.73
18	ПИЧ	20	1.28

Дүгнэлт: Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй "Металл майнинг" ХХК-ний үйлдвэрлэл явуулж буй хагдалын сангийн уснаас дээж авч шинжилгээ хийн 6561:2015 стандартай харьцуулахад хүлцэх агууламж нь стандартаас давсан үзүүлэлтгүй байна.

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ын инженер Г.Насанжаргал  
МУХ-ийн дарга Б.Нандинбат



Шинжилгээний дүн



БУЛГАН ЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ХАРЪЯА  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Булган аймгийн Бүрэгхангай суманд үйл ажиллагаа явуулж буй  
“Фокусметалл майнинг” ХХК-ний орчны хяналт шинжилгээний дүн  
Агаар, хөрсний шинжилгээний дүн

Дээжний хэмжээ..... Хөрс-1.0кг  
Дээжний дугаар..... № 28  
Дээж ирүүлсэн газрын нэр..... “Фокусметалл майнинг” ХХК  
Дээж авсан газрын нэр..... “Агаар, хөрсний шинжилгээ”  
Сорьц авсан огноо..... 2022.08.20  
Шинжилсэн огноо..... 2022.08.30  
Шинжилсэн аргачлал..... Агаар MNS 4585:2016., Хөрс MNS 5850 : 2008

1. Агаар MNS 4585:2016

Дээж авсан цэг	SO <sub>2</sub> мг/м <sup>3</sup>	NO <sub>2</sub> мг/м <sup>3</sup>	Тоос мг/м <sup>3</sup>	Цацраг мг/м <sup>3</sup>
Ил уурхайн талбай	0,014	0,025	0,5	0,16
Камп	0,008	0,016	0,3	0,10
Хүлцэх агууламж	0,45	0,085	0,5	0,60

2. Хөрс MNS 5850 : 2008

д/д	Сорьц авсан цэг	Чийг %	pH	NH <sub>4</sub> мг/кг	NO <sub>3</sub> мг/кг	SO <sub>4</sub> мг/кг	P <sub>2</sub> O <sub>5</sub> мг/кг	Pb (мг/кг)	Cu (мг/кг)	Cd (мг/кг)	Нефть мг/кг
1	Шимт хөрсний овоолго	26	7.69	22,6	32,6	107,6	76,2	17,6	13,8	0,3	-
2	Камп	33	7.16	28,3	21,2	113,5	33,6	20,7	32,4	0,4	0,2
3	Шатахуун агуулах	35	8.52	15,4	18,6	155,4	64,8	88,6	78,2	1,0	1,6
5	Хүлцэх агууламж	-	-	-	-	-	-	100	100	3	2,0

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер Г.Насанжаргал  
Хянасан: БОШЛ-ийн ахлах инженер М.Насанжаргал  
УЦУОШТөвийн дарга С.Жаргалсайхан



БУЛГАН ЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ХАРЪЯА  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Булган аймгийн Бүрэгхангай суманд үйл ажиллагаа явуулж буй  
“Фокусметалл майнинг” ХХК-ний орчны хяналт шинжилгээний дүн  
Усны шинжилгээний дүн

Дээжний хэмжээ..... Ус-1.5л  
Дээжний дугаар..... № 25  
Дээж ирүүлсэн газрын нэр..... “Фокусметалл майнинг” ХХК  
Дээж авсан газрын нэр..... “Ундны ус, хаягдал нуурын ус”  
Сорьц авсан огноо..... 2022.08.20  
Шинжилсэн огноо..... 2022.08.24-30

Шинжилгээний үр дүн

№	Усны химийн шинжилгээний үзүүлэлт, нэгж	Шинжилгээний аргачлал	MNS ISO 0900:2018 ЗДХ	Ундны ус	MNS ISO 4943:2015 ЗДХ	Хаягдал нуурын ус
1	pH-Усны орчин	MNS ISO10523:2001	6,5-8,5	7.52	6-9	8.47
2	Ес-ЦДЧ, (µs/cm)	MNS ISO7898:1999	1.0	0.90	-	271.0
3	Хатуулаг, (мг-экв/л)	MNS ISO6059:2005	7.0	4.56	-	-
4	Кальци, (мг/л)	MNS 1097:1970	100.0	44.1	-	-
5	Магни, (мг/л)	MNS 1097:1970	30.0	22.6	-	-
6	Натри+Кали, (мг/л)	MNS 1097:1970	200.0	25.0	-	-
7	Хлорид, (мг/л)	MNS 4424:2005	300	30.9	-	17.7
8	Нитрат, (мг/л)	MNS1097:1970	50	0.056	-	0.89
9	Нитрит, (мг/л)	MNS 6779:2019	1.0	0.007	-	0.024
10	Аммони, (мг/л)	MNS ISO 8467:1999	1.5	0.16	-	0.10
11	Нийт азот (мг/л)				15*	1.0
11	Төмөр, (мг/л)	MNS 4430:2005	0.3	0.03	-	0.16
12	Фосфат, (мг/л)	MNS 6878:2001	0.1	0.064	1.5*	0.60
13	Сульфат, (мг/л)	MNS 6271:2011	500	22.6	-	47.1
14	Гидрокарбонат, (мг/л)	MNS 6832:2020	-	-	-	-
15	Жинлэгдэх бодис (мг/л)	MNS ISO 11923:2001	-	-	30	29.2
16	Эрдэжилт (мг/л)	MNS1097:1970	-	-	1000	-
17	Фтор	MNS 6272:2011	1.5	1.05	-	-
18	ПИЧ	MNS ISO 6833:2020	-	-	20	1.64
19	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч ХХХ	MNS ISO 6060:2001	-	-	50	42
20	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	MNS ISO 5815:2015	-	-	20	14

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер Г.Насанжаргал  
Хянасан: БОШЛ-ийн ахлах инженер М.Насанжаргал  
УЦУОШТөвийн дарга С.Жаргалсайхан



Шинжилгээний дүн

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаар дахь NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , CO <sub>2</sub> , PM2.5, PM 10-ийн агууламж шинжлүүлэх	Уурхайн эдэлбэр талбайд	Булган аймгийн УЦУОШТ-ийн лаборторид 2 удаа шинжилгээ хийлгэхэд агаар дахь NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , CO <sub>2</sub> , PM2.5, PM 10-ийн агууламж стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байна.	Агаарын тухай хууль /2012/
Ундны усны ерөнхий химийн шинжилгээ	Ундны усанд	Булган аймгийн УЦУОШТ-ийн лаборторид 2 удаа шинжилгээ хийлгэхэд ундны ус, хаягдлын сангийн химийн найрлагын үзүүлэлт стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байна.	MNS 900-2010
Хөрсний үржил шимийн үзүүлэлт, механик бүрэлдэхүүн (рН, ялзмаг, карбонат, Ca <sup>2+</sup> Mg <sup>2+</sup> , K <sub>2</sub> O, P <sub>2</sub> O <sub>5</sub> )	Шимт хөрс, эвдрэлд ороогүй талбай	Булган аймгийн УЦУОШТ-ийн лаборторид 2 удаа шинжилгээ хийлгэхэд хөрсний үржил шимийн үзүүлэлт, механик бүрэлдэхүүн стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байна.	MNS 5820:2008
Төслийн талбай болон тухайн орчны ургамлан нөмрөгийн зүйлийн бүрдэл, тархалт, доройтлын өнөөгийн түвшин Тухайн орчны амьтны аймгийн зүйлийн бүрдэл, үхэл хорогдлын өнөөгийн байдал	Төслийн талбай болон түүний орчны талбай	Уурхайн орчинд тархсан ургамал, амьтны төрөл зүйл ажиглалт тандалт хийсэн бөгөөд ямар нэг сөрөг нөлөө, үхэл хорогдол ажиллагдаагүй.	“Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах хөтөлбөр”

## АРВАН НЭГ. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛЫН БИЕЛЭЛТ

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих, байгалийн тэнцвэртэй байдлыг хадгалах, цөлжилтийг багасгах, усны нөөцийг хадгалах зэрэгт ногоон орчин бүрдүүлж мод тарих нь чухал үүрэгтэй. Тиймээс мод ургамлыг нөхөн сэргээх, ургуулах зорилгоор шат дараатайгаар төслийн ашиглагдсан талбай болон тухайн бүс нутагт 200000 мод бутлаг ургамал тариалах ажлыг шат дараатай явуулахаар төлөвлөсөн. Эхний жилд 1,5 га талбайд 2500 ширхэг улиас, бургасны суулгац тарилаа. Мөн мод үржүүлгийн газар байгуулан 40000 ш хайлаас, 500 ш шар хуайс үржүүлэн ургуулж байна.



*“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн 2030 он хүртэл 200000 мод тарих батламж аймгийн Засаг даргаас гардан авлаа.*



*Намрын тарилт хийсэн байдал*



*Мод үржүүлгийн газар*

**АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хуваарь 2022 он									Гүйцэтгэл
	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	08 сар	09 сар	10 сар	11 сар	
Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах	+			+			+			Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг 7 хоногт 2 удаа зохион байгуулж байна.
Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд хоёр удаа зохион байгуулах, холбогдох дүүргийн байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	+						+			Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлыг ангилан ялгах сургалтыг уурхайн ажилчдад 2 удаа зохион байгуулж, тогтмол мэдээлэл зөвлөмж өгч ажиллаж байна. Мөн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, сумын ЗДТГ-ын холбогдох албан хаагчидтай нийт 12 удаа уулзаж, зөвлөгөө мэдээлэл авч, харилцан санал солилцож ажиллалаа.
Ажиллагсдыг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах.				+						Уурхайн ажиллагсдыг жилд 3 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.
Гал унтраах хэрэгслээр уурхайг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	+									Гал унтраах багаж хэрэгслээр уурхайг бүрэн хангаж 8 галын булан байгуулан бэлэн байдалд ажиллаж байна.
Орчны хяналт шинжилгээний ажлыг зохион байгуулах, дээжлэлтийг стандартын дагуу авж итгэмжлэгдсэн лабораторд шинжлүүлэхээр илгээх	+		+	+			+	+	+	Булган аймгийн УЦУОШТ-ийн лаборторид хөрс, ус, агаарын шинжилгээг 2 удаа хийлгэсэн.



**Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт**

БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Гүйцэтгэл
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Булган аймгийн Бүрэгхангай сумын засаг захиргааны байгууллагад танилцуулж, хэлэлцүүлнэ.	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумдын засаг захиргаанд хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлт	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг гарган биелэлтийн цахимаар хүргүүллээ.
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Булган аймгийн Бүрэгхангай сумын нутгийн оршин суугчдад танилцуулж хэлэлцүүлнэ.	Нутгийн оршин суугчдад БОМТ-ний биелэлтийг тайлагнах	БОМТ-ний биелэлт	БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Булган аймгийн Бүрэгхангай сумын 3-р багийн Иргэдийн Нийтийн Хуралд танилцуулж, хэлэлцүүллээ.



## ДҮГНЭЛТ

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулахдаа 2019 оны 10 сарын 29 –ний өдрийн БОАЖЯ-ийн сайдын А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг удирдлага болгов. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажилласан.

Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Захцаг уул, Худаг байшинт төмрийн хүдрийн ордын 2022 оны байгаль орчны менежментийн биелэлтийг хэрэгжүүлэн ажиллахад дараах зардал зарцуулсан байна.

Хүснэгт 3

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	Төсөв /сая төгрөг/	Тайлбар
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан	6,5	Уурхайн авто зам, зогсоолд хайрган хучилт хийж, тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан.
2.	Нөхөн сэргээлтийн тайлан	-	Энэ онд хөрс хуулалт хийгдээгүй, нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй болно.
3.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний тайлан	5.1	Уурхайн ойр орчмын 32 айл өрхөд тус бүр 10 боодол ногоон тэжээл тараах ажлыг хэрэгжүүллээ.
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний тайлан	-	
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний тайлан	-	
6.	Хог, хаягдлын менежментийн тайлан	3,0	Ангилан ялгах хогийн цэг, хаягдал тос хадгалах цэг байгуулсан.

7.	Химийн бодисын эрсдэлийн менежментийн тайлан	-	
8.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,0	Ундны ус, хаягдал ус, хөрс, агаарын шинжилгээг тус бүр 2 удаа хийлгэсэн.
9.	Удирдлага зохион байгуулалтын тайлан	3,6	Сургалт зохион байгуулах, сурталчилгааны материал бэлтгэх болон 8 галын булан байгуулсан.
10.	Байгаль орчны менежментийн биелэлтийн тайланг хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах хуваарь	0,1	БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Булган аймгийн Бүрэгхангай сумын 3-р багийн Иргэдийн Нийтийн Хуралд танилцуулж, хэлэлцүүлээ.
<b>2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт зардал</b>		<b>19,3</b>	